



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/157

Алтай хот

Гамшгийн сангаас хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 161 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр", Шадар сайдын баталсан хуваарь, төлөвлөгөөний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 14-ний өдрүүдэд гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах бэлтгэл ажлын болон сургалтын үйл ажиллагаанд шаардагдах 21,236,000 (хорин нэгэн сая хоёр зуун гучин зургаан мянга) төгрөгийг Гамшгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР